

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн инженерүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл худалдан авах

Төслийн дугаар: ОР-96/2020

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2020 оны 03 дугаар сарын 11-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн инженерүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-96/2020**

Орхон аймгийн ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн инженерүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл худалдан авах** тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 08 цаг 00 минут**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 23-ны 08 цаг 10 минутад** Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны **Сургалт мэдээллийн танхимд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын 70358570 утсаар авч болно.

**Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас:70358570**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**

Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - Үнийн санал маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.
 - Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ.
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх
 - Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх
 - Компанийн танилцуулга ирүүлэх
 - Шүүхийн тодорхойлолт
 - Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газрын тодорхойлолт
 - Чадварын мэдээлэл /өмнө нь гүйцэтгэсэн ажлын туршлагын мэдээлэл, гэрээ, гэрээг дүгнэсэн акт ирүүлнэ./
 - Нийлүүлэхээр санал болгож буй барааны техник үзүүлэлт /техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт/-ыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх
 - Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай албан бичиг ирүүлэх
 - Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
 - Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх
 - Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /1 жилээс багагүй байх/
 - Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдтэй нэгдмэл

- сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
 - Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх
- 4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Шаардахгүй. Санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn-ээс тендерт оролцогчийн санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>Татварын тодорхойлолт: Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>Туршлагын мэдээлэл /гэрээ, хүлээлгэн өгсөн акт ирүүлэх шаардлагатай./</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн тоон гарын үсгийг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг Төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн Тендерийн баримт бичгийн “ТОДРУУЛГА” хэсэгт байрлуулах тул тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим сайтыг байнга шалгаж байхыг зөвлөж байна.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл , баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт Adobe PDF шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод гаргацтай байх шаардлагатайг анхаарна уу. Уг шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Цаг: 08 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: ТЕНДЕРИЙГ ЦАХИМААР ДАРААХ ГАЗАРТ НЭЭНЭ. Байшин, гудамжны нэр: Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: Нэг цэгийн үйлчилгээ, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны Сургалт мэдээллийн танхим Аймаг, хот: Орхон аймаг, Баян-Өндөр сум Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Цаг: 08 цаг 10 минут</p>

<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн тодорхойлолт 2. Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газрын тодорхойлолт 3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай албан бичиг ирүүлэх 4. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх 5. Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх 6. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй.</p>

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

- 1. Барааны тодорхойлолт:** Нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо ширхэг хангасан байна.
- 2. Стандарт:** Нийлүүлэгдэх бараа ОУ-ын эсвэл гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.
- 3. Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолыг стандартын дагуу хийж эцсийн цэгт хүргэнэ. Түүнээс гарах бүх эрсдлийг нийлүүлэгч хариуцна.
- 4. Бараа хүргэх газар:** Орхон аймгийн Мэдээллийн шуурхай удирдлагын төв УТҮГАЗАР
- 5. Шалгалт, туршилт:** Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор захиалагч болон ашиглагч байгууллага нь барааг шалгаж туршилтаар ажиллуулж үзэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг тендерт оролцогч эх хувиар тендерт баталгаажуулан ирүүлнэ.

Барааны тодорхойлолт:

№	Барааны нэр	Хэмжих нэгж	тоо ширхэг	Техникийн тодорхойлолт
1	Зөөврийн компьютер	ширхэг	1	CPU: core i5 түүнээс дээш Ram: 4gb түүнээс дээш HDD: 512 GB түүнээс дээш Display and graphics DVD-RW Dell брэндийн эсвэл түүнтэй дүйцэх
2	Operating System	ширхэг	2	Windows 7; 8; 10 /32-64 bit/ all version
3	Зөөврийн хард диск	ширхэг	1	HDD: 120GB SATA USB 3.0
4	Флаш диск	ширхэг	2	HDD: 120GB SATA USB 3.0
5	USB DVD ROM; RW	ширхэг	1	Windows XP/Vista/7/8.1/10 үйлдлийн системтэй ажиллах Read 24x; write 16x хурдтай байх, USB 3.0 технологийн
6	Антивирус	ширхэг	2	Kaspersky internet security multi device 2019; Bitdefender, 1 жилийн албан ёсны эрхтэй.
7	Гагнуурын алх, тугалга сорогч, томруулдаг шил	ширхэг	1	Индикатор гэрэлтэй, температур тохируулдаг Гадар керамик халаагчтай Өндөр халуунд тэсвэртэй хуванцар бариул Хар тугалгүй гагнуурын технологи Нарийн үзүүртэй, ашиглахад хялбар

8	HDMI; DVI; VGA cable	ширхэг	8	4 метрийн урттай байх
9	CD	ширхэг	1	CD 700 MB
10	DVD	ширхэг	1	DVD 4.7 GB /8.5 GB/
11	HDD уншигч	ширхэг	1	2 Serial ATA SATA Hard Drive; USB 3.0 interface
12	Чихэвч	ширхэг	2	On-Ear; 3.5 mm plug; built-in microphone
13	Спикер	ширхэг	2	2*1 speaker with subwoofer; subwoofer; 50w speaker:20W
14	Дижитал камер	ширхэг	1	Nikon Coolpix P900; 16 megapixel нягтаршилтай, 83*optical zoom-тэй, /Nikkor ED шилэн линзтэй/ Full HD 1080p
15	Суурин радио станцын холбогч кабель	ширхэг	1	Суурин радио станцын холбогч кабель /KPG-46U/, микро чиптэй байх
16	Гар радио станцын холбогч кабель	ширхэг	1	Гар радио станц тохируулах програм хангамж /KPG-D3/, микро чиптэй байх
17	Суурин радио станцын тохиргооны програм хангамж, лиценз	ширхэг	1	Суурин радио станц тохируулах програм хангамж /KPG-141D/, албан ёсны лицензтэй байх
18	Гар радио станцын тохиргооны програм хангамж, лиценз	ширхэг	1	Гар радио станц тохируулах програм хангамж /KPG-D3/, албан ёсны лицензтэй байх
19	Тэжээлийн блок	ширхэг	1	Трансформатран тэжээлийн блок, хүчдэл, гүйдлийн хэмжигчтэй байх, гаралтын хүчдэл тохируулдаг байх
20	Тэжээлийн блок	ширхэг	14	Суурин станцуудад ашиглах, 12V 15A
21	Шилэн кабелийн залгааны машин	ширхэг	1	Шилэн кабелийг гагнаж залгах машин иж бүрнээрээ дагалдах хэрэгслийн хамтаар, хүйтэнд ажиллах боломжтой байх, нөөц электродтой байх
22	Шилэн кабелийн гэмтэл тодорхойлогч, OTDR	ширхэг	1	0.5 /1/2/4/8/16/32/64/128/256 km зайд хэмжилт хийх чадалтай, өөр дээрээ лазер болон чадлын тестертай сингл корын, гадаа хүйтэн нөхцөлд ажиллах боломжтой.
23	Сүлжээний засварын комп багаж	ширхэг	1	Бахь, отверкны ком, хямсаа, жак дарагч гэх мэт бусад багажны хамт tajima брэндийн эсвэл түүнтэй дүйцэх
24	Шилэн кабелийн ком багаж	ширхэг	1	Шилэн кабелийн үзүүрлэгч, тасдагч, цаасны хутга, тусгай түлхүүр гэх мэт PROSKIT брэндийн эсвэл түүнтэй дүйцэх

25	Шилэн кабелийн лазер	ширхэг	1	650 nW 10 km range
26	Шилэн кабелийн чадлын тестер	ширхэг	1	Шилэн кабелиар дамжиж буй сигналын чадлыг хэмжинэ.
27	Камер тестер буюу тохируулагч	ширхэг	1	8 MP TVI; 8 MP CVI; 8MP AHD HDMI input PTZ controller UTP Cable Tester BNC Cable Tester DC12V output DC 12V 1A Power Adapter Өөрөө 12 волтын гаралттай бөгөөд ямар ч IP камерт залгаад шууд дүрс харах боломжтой, TCP/IP дэмждэг байх
28	Сүлжээний кабелийн тестер байршил тогтоогч	ширхэг	2	9V; led indicators; audio signal-тай байх, зэс кабелийн гэмтлийг тодорхойлж мөн дуут дохиогоор хайж олдог байх

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Зөөврийн компьютер	CPU: core i5 түүнээс дээш Ram: 4gb түүнээс дээш HDD: 512 GB түүнээс дээш Display and graphics DVD-RW Dell брэндийн эсвэл түүнтэй дүйцэх	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Operating System	Windows 7; 8; 10 /32-64 bit/ all version	2	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Зөөврийн хард диск	HDD: 120GB SATA USB 3.0	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Флаш диск	HDD: 120GB SATA USB 3.0	2	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
USB DVD ROM; RW	Windows XP/Vista/7/8.1/10 үйлдлийн системтэй ажиллах Read 24x; write 16x хурдтай байх, USB 3.0 технологийн	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Антивирус	Kaspersky internet security multi device 2019; Bitdefender, 1 жилийн албан ёсны эрхтэй.	2	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Гагнуурын алх, тугалга сорогч, томруулдаг шил	Индикатор гэрэлтэй, температур тохируулдаг Гадар халаагчтай керамик Өндөр халуунд тэсвэртэй хуванцар Хар тугалгүй гагнуурын технологи Нарийн үзүүртэй, ашиглахад хялбар	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

HDMI; DVI; VGA cable	4 метрийн урттай байх	8	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
CD	CD 700 MB	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
DVD	DVD 4.7 GB /8.5 GB/	1	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
HDD уншигч	2 Serial ATA SATA Hard Drive; USB 3.0 interface	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Чихэвч	On-Ear; 3.5 mm plug; built-in microphone	2	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Спикер	2*1 speaker with subwoofer; subwoofer; 50w speaker:20W	2	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Дижитал камер	Nikon Coolpix P900; 16 megapixel нягтаршилтай, 83*optical zoom-тэй, /Nikkor ED шилэн линзтэй/ Full HD 1080p	1	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Суурин радио станцын холбогч кабель	Суурин радио станцын холбогч кабель /KPG-46U/, микро чиптэй байх	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Гар радио станцын холбогч кабель	Гар радио станц тохируулах програм хангамж /KPG-D3/, микро чиптэй байх	1	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Суурин радио станцын тохиргооны програм хангамж, лиценз	Суурин радио станц тохируулах програм хангамж /KPG-141D/, албан ёсны лицензтэй байх	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Гар радио станцын тохиргооны програм хангамж, лиценз	Гар радио станц тохируулах програм хангамж /KPG-D3/, албан ёсны лицензтэй байх	1	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Тэжээлийн блок	Трансформатран тэжээлийн блок, хүчдэл, гүйдлийн хэмжигчтэй байх, гаралтын хүчдэл тохируулдаг байх	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Тэжээлийн блок	Суурин станцуудад ашиглах, 12V 15A	14	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Шилэн кабелийн залгааны машин	Шилэн кабелийг гагнаж залгах машин иж бүрнээрээ дагалдах хэрэгслийн хамтаар, хүйтэнд ажиллах боломжтой байх, нөөц электродтой байх	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Шилэн кабелийн гэмтэл тодорхойлогч, OTDR	0.5 /1/2/4/8/16/32/64/128/256 km зайд хэмжилт хийх чадалтай, өөр дээрээ лазер болон чадлын тестертай сингл корын, гадаа хүйтэн нөхцөлд ажиллах боломжтой.	1	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Сүлжээний засварын комп багаж	Бахь, отверкны ком, хямсаа, жак дарагч гэх мэт бусад багажны хамт tajima брэндийн эсвэл түүнтэй дүйцэх	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Шилэн кабелийн ком багаж	Шилэн кабелийн үзүүрлэгч, тасдагч, цаасны хутга, тусгай түлхүүр гэх мэт PROSKIT брэндийн эсвэл түүнтэй дүйцэх	1	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Шилэн кабелийн лазер	650 nW 10 km range	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Шилэн кабелийн чадлын тестер	Шилэн кабелиар дамжиж буй сигналын чадлыг хэмжинэ.	1	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Камер тестер буюу тохируулагч	8 MP TVI; 8 MP CVI; 8MP AHD HDMI input PTZ controller UTP Cable Tester BNC Cable Tester DC12V output DC 12V 1A Power Adapter Өөрөө 12 волтын гаралттай бөгөөд ямар ч IP камерт залгаад шууд дүрс харах боломжтой, TCP/IP дэмждэг байх	1	шихэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Сүлжээний кабелийн тестер байршил тогтоогч	9V; led indicators; audio signal-тай байх, зэс кабелийн гэмтлийг тодорхойлж мөн дуут дохиогоор хайж олдог байх	2	ширхэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
Барааг хүлээн авах комисс шалгаж, туршиж актаар хүлээн авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор захиалагч болон ашиглагч байгууллага нь барааг шалгаж туршилтаар ажиллуулж үзэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг тендерт оролцогч эх хувиар баталгаажуулан ирүүлнэ.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Баталгаат хугацаа 1 жилээс багагүй байна.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнэ төгрөгөөр төлөгдөнө.
Урьдчилгаа төлбөр: Олгохгүй.
Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Олгохгүй.
Барааг хүлээн авч акт үйлдсэний дараа төлөх: Захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлбөрийг 100 хувь олгоно.
- Гэрээний үнийн дүнгийн [моо]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²**
- a. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн дүнгийн 0,1 хувиар
 - b. Алдангийн нийт дүн: Алдангийн дээд хязгаар нь гэрээний нийт

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

дүнгийн 10 хувь байна. Дээд хязгаар хэтэрсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцална.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]